



**ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Ажлын хувцас, хэрэгсэл олгох,  
хэрэглэх журам, стандарт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ажилчдын “Ажлын хувцас, хэрэгсэл олгох ашиглах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Ажлын тусгай хувцас-ерөнхий шаардлага” стандартыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах инженер бөгөөд хөдөлмөр хамгааллын инженер (Д.Отгонжаргал), Өмч хамгаалах, үнэ тогтоох байнгын комисс (Д.Батсайхан)-т даалгасугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2017 оны 03-р сарын 31-ний 82 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Хавсралт ᠗ хуудастай

ЗАХИРАЛ



Ө.ЛУВСАНРЕНЧИН



## АЖЛЫН ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

NUG-J-046

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар /цаашид “ЗГБНҮГ” гэх/-ын нийт ажилчдад ажлын хувцас, хэрэгслээр хангах, заавар болон зориулалтын дагуу тогтмол, зөв хэрэглэж хэвшүүлэх, бүртгэх, хянах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслүүдийн стандартуудыг удирдлага болгосон бөгөөд тус байруудын нийт ажилтнууд дагаж мөрдөнө.

1.3. Нэг ажилтанд ноогдох ажлын хувцасны норм, хугацааг А хавсралтаар, Инженер техникийн ажилтны ажлын хэрэгслийн норм хугацааг Б хавсралтаар, Үйлчилгээний ажилтнуудын ажлын хэрэгслийн норм, хугацааг В хавсралтаар тус тус батлав.

### Хоёр. Ажлын хувцас, хэрэгслийн ерөнхий шаардлага

2.1. Ажлын хувцасны өнгө, загвар, иж бүрдлийг захирал батална.

2.2. Ажлын хувцас нь батлагдсан өнгө загвар, иж бүрдэл бүхий стандартын шаардлага хангасан байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. Ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь тухайн ажилтанд саад болохгүй байх;

2.2.2. Ажилтныг шаардагдах түвшинд хамгаалахаас гадна биед тохиромжтой, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх;

2.2.3. Ажлын хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц ирмэггүй байх;

2.2.4. Хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна, хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц эсвэл хэмжээний өргөн сонголттой байх;

2.2.5. Хувцасны хамгаалалтын түвшин өндөр, эдийн засгийн үр ашигтай байх;

2.2.6. Ажлын хувцас нь боломжтой хэмжээгээр гаднаас ус уур нэвтрүүлэхгүй, биед нөлөөлөх гадны хүчин зүйлийг багасгах нөлөөтэй байх;

2.2.7. Хамгаалах хэрэгслүүд нь MNS4931:2000, 5388:2004, 5389:2004, 5620:2006, 5621:2006, 5622:2006, 5624:2006 стандартуудыг хангасан байх;

2.2.8. Хамгаалах хэрэгсэл бүр баталсан норматив техникийн баримт бичигтэй, биеийг гадны нөлөөллөөс бүрэн хамгаалах чадвартай, гоо зүйн болон эргономикийн шаардлага хангасан байх;

2.3. Ажилтан өөрийн ажлыг хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах үүрэгтэй.

2.4. Ээлжийн амралт, хуваарьт амралт, ажлын бус цагаар ажлын хувцас хэрэгслийг хэрэглэхийг хориглоно.

### **Гурав. Ажлын хувцас, хэрэгсэл олгох**

3.1. Ажилтан, албан хаагчдад тогтоосон нормын дагуу ажлын хувцас хэрэгслийг олгохдоо холбогдох хэлтсүүд Санхүү бүртгэлийн хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр ажлын хувцас олгох ба ажлын хувцас олгох хуваарийг үндэслэн хариуцсан нягтлан бодогчийн зөвшөөрлөөр нярав олгож бүртгэлжүүлнэ.

3.2. Шинээр ажилд орсон болон ажлын тусгай хувцас, хэрэгслийн эдэлгээний хугацаа дууссан ажилтнуудад батлагдсан нормын дагуу хувцас шинээр олгоно.

3.3. Ажлын хувцас, хэрэгслийн хугацаа дууссан, ажлын нөхцөлөөс шалтгаалан дахин ашиглах боломжгүй болсон, аюулгүйн шаардлага хангахгүй болох зэрэг шалтгааны улмаас солих шаардлага гарсан бол шууд удирдах ажилтнаар тодорхойлолт хүсэлт бичүүлж, тухайн ажилтан шаардах хуудас бичиж, нягтлан бодогчийн зөвшөөрлийг авсныг үндэслэн шинээр олгоно.

3.4. Ажлын хувцас хэрэгслийн нөөцийг тухайн жилийн нийт ажилчдын 20 хүртэлх хувиар тооцно.

### **Дөрөв. Ажлын хувцас хэрэгслийн ашиглалт, хэрэглээ**

4.1. Ажлын хувцас, хэрэгслийг зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх үедээ зориулалтын дагуу хэрэглэж, нормын хугацаанд бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана.

4.2. Ажлын хувцас эзэмшигч нь эдэлгээний хугацаанаас илүү хугацаагаар хэрэглэж хэмнэлт гаргасан тохиолдолд хэмнэсэн зардлын 50 хувиар ажилтныг урамшуулна.

4.3. Эзэмшигч нь санаатай болон санамсаргүй байдлаас ажлын хувцас, хэрэгслийг ашиглалтын хугацаанаас өмнө чанарыг муутгасан, хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн зэргээр дахин ашиглах боломжгүй болсныг Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, хариуцсан нярав, холбогдохын хэлтсийн дарга, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй комисс хэлэлцэн тогтоож байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.4. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын нөхцөл болон элгэгдлээр нь тооцно.

4.5. Ажлын хувцсыг ашиглалтын хугацаанаас өмнө хэрэглээний шаардлага хангахааргүй болгосон тохиолдолд эд хөрөнгийн бүртгэл хяналтын картад тусгасан дүнгээс элэгдэл хорогдлыг тооцсон дүнгээр байгууллагад учруулсан хохирлыг барагдуулна.

4.6. Ажилтан, албан хаагч нь ажлын хувцас, хэрэгслийн үнийг бүрэн төлж дуусгасан үед дахин олгож болно.

4.7. Эзэмшигч ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зайлшгүй шалтгааны улмаас /аваар осол гэх мэт/ ажлын хувцас, хэрэгслийг дахин ашиглах боломжгүй болгосон тохиолдолд акт тогтоон Санхүү бүртгэлийн хэлтэст хандан уг ажилтанд шинээр олгоно.

4.8. Ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд ажилласан хугацаагаар хувцасны элэгдэл тооцож, санхүүтэй тооцоо нийлнэ.

### **Тав. Хяналт, хариуцлага**

5.1. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, мөрдүүлж ажиллах үүргийг ХАБЭА-н асуудал хариуцсан инженер хариуцах бөгөөд журам зөрчсөн ажилтанд шаардлага тавьж зөрчлийг арилгах эрхтэй.

5.2. Журам зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон энэхүү журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.3. Ажилтан санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас ажлын хувцас, хэрэгслийг дахин хэрэглэх боломжгүй болгосон тохиолдолд энэхүү журмын 4 дүгээр зүйлд зааснаар хохирлыг барагдуулж, хариуцлага хүлээнэ.


5.4. Ажилтны шууд удирдлага нь ажлын хувцас, хэрэгслийн ашиглалтад хяналт тавих, ажлын байрнаас өөр газарт хэрэглэх зэргээр энэхүү журамд заасан зөрчлийг гаргасан ажилтанд арга хэмжээ авах санал захиргаанд гарган шийдвэрлүүлэх эрхтэй.

----- оОо -----

## А.ХАВСРАЛТ

Ажилтан, албан хаагчдын ажлын хувцасны норм ба эдэлгээний хугацаа

№	Албан тушаал	Ажлын хувцас хэрэгсэл	Тоо хэмжээ	Орон тоо	Эдэлгээний хугацаа
1	Эмч	Эмчийн цамц, цагаан халат	1 ширхэг	2	2 жил
2	Цай зөөгч	Пиджак, жилет, юбка, цагаан цамц	1 ширхэг	8	2 жил
3	Үйлчлэгч /өрөө/	Ажлын өмд, цамцны хослол	1 ширхэг	132	2 жил
		Хүйтний улиралд зузаан цамц	1 ширхэг		
4	Үйлчлэгч /ариун цэврийн өрөө/	Ажлын өмд, цамцны хослол	1 ширхэг	22	2 жил
		Хүйтний улиралд зузаан цамц	1 ширхэг		
		Амны хаалт			
5	Гадна талбайн үйлчлэгч	Ажлын өмд, цамц	1 ширхэг	2	2 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд куртканы хослол	1 ширхэг		2 жил
		Хүйтний улиралд хөвөнтэй бээлий	1 ширхэг		6 сар
6	Манаач	Ажлын өмд, цамц	1 ширхэг	8	2 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд, хүрэм	1 ширхэг		2 жил
7	Сантехникч	Ажлын өмд, цамц	1 ширхэг	29	2 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд, хүрэм	1 ширхэг		3 жил
		Зузаан бээлий	1 ширхэг		6 сар
		Обув цув	1 ширхэг		2 жил
		Усны гутал	1 ширхэг		2 жил
8	Цахилгаанчин, лифтчин	Ажлын өмд, цамц	1 ширхэг	9	2 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд, хүрэм	1 ширхэг		3 жил
		Хөвөнтэй бээлий	1 ширхэг		6 сар
		Зузаан бээлий	1 ширхэг		Улиралд
9	Мужаан	Ажлын өмд, цамц	1 ширхэг	8	2 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд, хүрэм	1 ширхэг		3 жил
		Зузаан бээлий	1 ширхэг		Улиралд
10	Инженер	Ажлын өмд, цамц	1 ширхэг	5	3 жил
		Хүйтний улиралд зузаан дотортой өмд, хүрэм	1 ширхэг		3 жил
11	Жолооч	Ажлын өмд, цамц	1 ширхэг	1	2 жил
12	Мэргэжилтэн	Бомбер	1 ширхэг	35	3 жил



## Б. ХАВСРАЛТ

Үйлчилгээний ажиллагсдын ажлын  
хэрэгсэл, бараа материалын норм ба  
хугацаа

№	Ажлын хэрэгслийн	Ашиглалтын хугацаа	Тоо
<b>Үйлчилгээний ажилтан</b>			
1	Тоос сорогч машин	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
2	Хивс болон чулуун шал угаагч машин	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
3	Өндрийн цэвэрлэгээний шат	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Хамгаалалтын бүс	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Цонх угаах иштэй татуурга	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Илгэн алчуур /шил, толь, компьютер арчих/	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг
7	Шал угаах алчуур	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 метр
8	<b>4 төрөл тоосны алчуур эсвэл зориулалтын мөн тооны өнгийн алчуур</b>	Ашиглалтын нөхцлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	2 метр
9	Резинэн бээлий	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 ширхэг
10	Малгай /1 удаагийн/	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
11	Амны хаалт /1 удаагийн/	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
12	Шал угаах сэгсрэгчтэй хувин	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
13	Шал угаах сэгсрэгчний запас алчуур	Ашиглалтын нөхцлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг
14	Шал угаах урт сойз	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
15	Нарийн цэвэрлэгээний жижиг сойз	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
16	Өндрийн цэвэрлэгээний тоос буулгах сэгсүүрэг	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
17	Хогийн тосгуур, шүүр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
18	Том хувин	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
19	Жижиг хувин	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
20	Мебель өнгөлөгч	Ашиглалтын нөхцлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	1 ширхэг

21	Шил толь өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш	1 ширхэг
22	Хивс угаагч бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1	1 ширхэг
23	Угаалгын нунтаг	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
24	Барааны саван	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	3 ширхэг
25	Гарын саван	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш	1 ширхэг
26	Гарын тос	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
27	Агааржуулагч /ариун цэврийн өрөө, хурлын заалны үйлчлэгчид олгоно/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 ширхэг
28	Паркет өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
29	Плита өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
30	Цайруулагч бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
31	Комет	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
32	Ариутгалын бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
33	Хогны уут /ариун цэврийн өрөө/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш	1 боодол
<b>Гадна талбайн үйлчлэгч</b>			
1	Хогны тэргэнцэр	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
2	Дэрсэн шүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2-4 сар	1 ширхэг
3	Хогийн тосгуур, шүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Цас түрэгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Цас цохигч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Хүрз	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Тармуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
8	Гар хадуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Гар хайч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
10	Ажлын даавуун бээлий	Ашиглалтын нөхцөлөөс	1 ширхэг
11	Амны хаалт	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг

## В.ХАВСРАЛТ

Инженер техникийн ажиллагсдын ажлын багаж хэрэгсэл,  
тоног төхөөрөмжийн норм ба хугацаа

№	Ажлын хэрэгсэл	Ашиглалтын хугацаа	Тоо хэмжээ
<b>Цахилгаанчин - 8</b>			
1	Цахилгааны гүйдэл хэмжих багаж	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Цахилгааны тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Индексатор	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Овтерканы багц	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Хүйтэн гагнуурын алх	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Метр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Цохилттой дрилль	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
8	Гагнуурын алх	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Бахь	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
<b>Мужаан - 8</b>			
1	Мужааны тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Өрөмдөгч багажны багц	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Гар хөрөө	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Овтерканы багц	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Метр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Алх	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Бахь	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
8	Тэгш ус	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Дрилль	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
10	Цохилттой дрилль	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг



11	Дрилльний нэмэх, хасах хошуу	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
12	Таслагч	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
13	Төмрийн хөрөө	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
14	Цахилгаан хөрөө	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
15	Харуул	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
<b>Слесарь - 29</b>			
1	Тасдагч машин	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Тусгай ком	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Слесарийн тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Гагнуурын аппарат	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Хоолой матагч /газов/	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Хоолойн резба татагч	Ашиглалтын нөхцлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
<b>Лифтчин - 1</b>			
1	Лифтний түлхүүр		

----- оОо -----

